



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/337

Мандалговь

Ойн зурвас хүлээн авах  
ажлын хэсэг байгуулах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэхь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот тушаалын хавсралтаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын 2020 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд Эрдэнэдалай, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан сумдад тус бүр 1 га нийт 5 га талбайд хийгдсэн ойн зурвасын ажлын гүйцэтгэлийг шалган хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Гантулга - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүд: П.Очирбат - (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Б.Цэрэнсугир - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ц.Галбадрах - (Сум дундын ойн ангийн дарга)

П.Уртнасан - (Сум дундын ойн ангийн мэргэжилтэн)

2. Ойжуулалт, ойн зурваст тарьж ургуулсан тарьц, суулгацын амьдралтын хувь хэмжээг тогтоож, акт, танилцуулгыг 2021 оны 10 дугаар сарын 05-ны дотор холбогдох газруудад хүргүүлэхийг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР

481210348